ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН  АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн  2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ЗАА-2022/86/СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улиастай сум<br>2022 он | Завхан аймаг дахь Төрийн Аудитын газрын тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа<br>Утас: 99993365<br>Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn<br><br>Ахлах аудитор  : Б.Дагвасүрэн<br>Утас:99014227<br>Цахим хаяг: dagvasurenb@audit.gov.mn<br><br>Аудитор Б.Жалбаа<br>Утас: 89330330<br>Цахим хаяг: jalbaab@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга


1. Аудитын санал дүгнэлт ........ 2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
3. Аудитын тайлан ........ 11
   3.1 Ерөнхий зүйл ........ 11
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........ 11
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 11
   3.4 Материаллаг байдал ........ 12
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........ 12
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 12
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........ 13
   3.8 Аудитын гол асуудал ........ 13
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 13
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 14
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 14
4. Аудитын илрүүлэлт ........ 14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 15


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
81000 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-36-12

2021. 02. 21 № 1802/68

танай______-ны №______-т

УЛИАСТАЙ СУМЫН ЖАВХЛАНТ ЦОГЦОЛБОР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Д.ПҮРЭВДОРЖ-Д

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

013022943

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/мян.төг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **236,397.52** | **311,994.49** |
| **33** | **АВЛАГА** | **2,713.90** | **1,053.10** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,713.90 | 1,053.10 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **233,683.62** | **310,941.40** |
| **351** | **Түүхий эд материал** | **0.00** | **340.00** |
| 35130 | Эм боох материал | 0.00 | 340.00 |
| **354** | **Хангамжийн материал** | **226,863.62** | **299,961.40** |
| 35410 | Бичиг хэргийн материал | 36,750.29 | 46,671.69 |
| 35420 | Аж ахуйн материал | 90,849.92 | 109,894.02 |
| 35450 | Барилгын засварын материал | 2,276.70 | 4,435.20 |
| 35460 | Хүнсний материал | 25,519.39 | 11,434.92 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 71,467.32 | 127,525.57 |
| 35600 | Мал амьтад | 6,820.00 | 10,640.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,393,380.56** | **1,324,415.40** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **1,393,380.56** | **1,324,415.40** |
| **392** | **Биет хөрөнгө** | **1,207,570.18** | **1,139,017.52** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 838,407.62 | 762,012.55 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -74,815.45 | -98,856.68 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 2,257.10 | 2,257.10 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -2,257.10 | -2,257.10 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 371,895.94 | 433,569.63 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -198,671.81 | -257,068.14 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 249,126.51 | 311,854.93 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -59,704.18 | -100,320.67 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 12,300.00 | 14,800.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -1,325.00 | -2,555.00 |
| 39217 | Ном | 70,356.56 | 75,580.91 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | **185,810.38** | **185,397.88** |
| 39301 | Програм хангамж | 3,214.97 | 3,214.97 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,805.60 | -2,218.10 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 184,401.00 | 184,401.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,629,778.08** | **1,636,409.89** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,629,778.08** | **1,636,409.89** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **1,629,778.08** | **1,636,409.89** |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 1,219,756.79 | 1,219,756.79 |
| 51101 | Өмч: - төрийн | 1,219,756.79 | 1,219,756.79 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | **-356,937.52** | **-277,010.31** |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -356,937.52 | -282,255.09 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 5,244.78 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 766,958.81 | 693,663.41 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,629,778.08** | **1,636,409.89** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/мян.төг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,356,000.15** | **2,038,605.94** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **212,555.49** | **118,870.09** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **212,555.49** | **118,870.09** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 212,555.49 | 118,870.09 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 23,764.52 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 188,790.97 | 118,870.09 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,143,444.66** | **1,919,735.85** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,904,631.70** | **1,627,420.50** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,904,631.70 | 1,627,420.50 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **207,646.60** | **230,411.60** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 207,646.60 | 230,411.60 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **31,166.36** | **61,903.75** |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 31,166.36 | 61,903.75 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **2,317,522.59** | **1,962,986.43** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,317,522.59** | **1,962,986.43** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,901,830.75** | **1,845,576.03** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,154,403.65** | **1,221,878.78** |
| 210101 | Үндсэн цалин | 878,407.53 | 830,309.18 |
| 210102 | Нэмэгдэл | 210,469.96 | 312,653.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 1,075.80 |
| 210104 | Урамшуулал | 65,526.16 | 77,840.15 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **147,460.49** | **159,445.92** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 101,654.34 | 110,999.53 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,544.04 | 12,517.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,865.23 | 9,794.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,308.81 | 2,435.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,088.07 | 23,698.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **208,357.56** | **220,745.53** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,962.88 | 8,680.63 |
| 210302 | Түлш, халаалт | 195,183.48 | 207,242.13 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,211.20 | 4,822.78 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **72,634.88** | **66,887.84** |
| 210401 | Бичиг хэрэг | 29,092.64 | 15,187.10 |

| | | | |
|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.00 | 8,651.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,148.00 | 3,110.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 560.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0.00 | 17,034.20 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 12,238.64 | 0.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 25,595.60 | 22,905.54 |
| **2105** | **Нормативт зардал** | **47,941.89** | **4,298.80** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 0.00 | 3,643.10 |
| 210502 | Хоол, хүнс | 47,941.89 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 655.70 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **62,640.98** | **16,121.60** |
| 210604 | Урсгал засвар | 62,640.98 | 16,121.60 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,792.57** | **7,882.70** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,642.57 | 3,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 4,282.70 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **205,598.74** | **148,314.86** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,870.69 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 17,597.97 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 149,728.05 | 130,716.89 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **415,691.84** | **117,410.40** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **20,851.76** | **112,513.88** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 0.00 | 73,453.27 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 20,851.76 | 37,060.61 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 2,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **4,314.60** | **4,896.52** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,314.60 | 4,896.52 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **390,525.48** | **0.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 390,525.48 | 0.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **38,477.56** | **75,619.51** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **9,607.71** | **70,374.73** |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 9,607.71 | 70,374.73 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | **-9,607.71** | **-70,374.73** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **28,869.85** | **5,244.78** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**СТ-4А**

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ мян.төг /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2013 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,219,756.79 | 776,162.61 | -395,011.17 | **1,600,908.23** |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 9,203.80 | **9,203.80** |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 1,219,756.79 | 776,162.61 | -385,807.37 | **1,610,112.03** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 28,869.85 | **28,869.85** |
| C08 | **2014 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,219,756.79 | 766,958.81 | -356,937.52 | **1,629,778.08** |
| D01 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,219,756.79 | 766,958.81 | -356,937.52 | **1,629,778.08** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | 74,682.43 | **74,682.43** |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 1,219,756.79 | 766,958.81 | -282,255.09 | **1,704,460.51** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | -73,295.40 | 0.00 | **-73,295.40** |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | 0.00 | **0.00** |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 5,244.78 | **5,244.78** |
| D09 | **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 1,219,756.79 | 693,663.41 | -277,010.31 | **1,636,409.89** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

**СТ-2А**

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/мян.төг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **2,167,209.18** | **1,919,735.85** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **23,764.52** | **0.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **23,764.52** | **0.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **23,764.52** | **0.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 23,764.52 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **2,143,444.66** | **1,919,735.85** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **1,904,631.70** | **1,627,420.50** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,904,631.70 | 1,627,420.50 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **207,646.60** | **230,411.60** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 207,646.60 | 230,411.60 |
| **1330** | **Төсвийн захирагчдаас** | **31,166.36** | **61,903.75** |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 31,166.36 | 61,903.75 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **2,089,843.08** | **1,875,732.95** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,089,843.08** | **1,875,732.95** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,651,918.14** | **1,769,170.01** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **1,154,403.65** | **1,221,878.78** |
| 210101 | Үндсэн цалин | 878,407.53 | 830,309.18 |
| 210102 | Нэмэгдэл | 210,469.96 | 312,653.65 |

| | | | |
|---|---|---|---|
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 1,075.80 |
| 210104 | Урамшуулал | 65,526.16 | 77,840.15 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **150,174.39** | **156,732.01** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 104,368.25 | 108,285.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 11,544.04 | 12,517.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 8,865.23 | 9,794.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,308.81 | 2,435.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,088.07 | 23,698.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **208,357.56** | **220,411.60** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,962.88 | 8,346.69 |
| 210302 | Түлш, халаалт | 195,183.48 | 207,242.13 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,211.20 | 4,822.78 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **51,304.90** | **71,889.71** |
| 210401 | Бичиг хэрэг | 18,890.10 | 17,199.61 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.00 | 8,784.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 5,148.00 | 2,608.40 |
| 210404 | Ном, хэвлэл | 0.00 | 2,472.50 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 560.00 | 0.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 0.00 | 40,824.80 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 26,706.80 | 0.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **0.00** | **27,355.60** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 0.00 | 4,149.70 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 23,205.90 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **37,697.66** | **17,864.60** |
| 210604 | Урсгал засвар | 37,697.66 | 17,864.60 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **2,792.57** | **8,790.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,642.57 | 4,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 4,790.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 150.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **47,187.42** | **44,247.71** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 47,187.42 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 44,247.71 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **437,924.94** | **106,562.93** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **43,084.86** | **101,666.41** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 22,233.10 | 62,605.80 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 20,851.76 | 37,060.61 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 2,000.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **4,314.60** | **4,896.52** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,314.60 | 4,896.52 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **390,525.48** | **0.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 390,525.48 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **77,366.10** | **44,002.90** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **77,366.10** | **44,002.90** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **77,366.10** | **44,002.90** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **77,366.10** | **44,002.90** |
| 223001 | Бусад хөрөнгө | 75,476.10 | 0.00 |
| 224001 | Стратегийн нөөц хөрөнгө | 240.00 | 0.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,650.00 | 44,002.90 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-77,366.10** | **-44,002.90** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТГ

**ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

/ мян.төг/

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,857,831.90 | 1,857,832.10 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,857,831.90 | 1,857,832.10 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,793,226.10 | 1,793,226.30 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,221,878.60 | 1,221,878.78 |
| 210101 | Үндсэн цалин | 830,309.10 | 830,309.18 |
| 210102 | Нэмэгдэл | 313,729.40 | 312,653.65 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 1,075.80 |
| 210104 | Урамшуулал | 77,840.10 | 77,840.15 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 156,732.00 | 156,732.01 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 108,285.70 | 108,285.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,517.30 | 12,517.35 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 9,794.40 | 9,794.38 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,435.70 | 2,435.70 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 23,698.90 | 23,698.96 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 220,411.60 | 220,411.60 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,354.40 | 8,346.69 |
| 210302 | Түлш, халаалт | 204,240.00 | 207,242.13 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,817.20 | 4,822.78 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 91,610.60 | 91,610.60 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,417.60 | 16,417.60 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8,784.40 | 8,784.40 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,608.40 | 2,608.40 |
| 210404 | Ном, хэвлэл | 6,626.40 | 6,626.40 |

| | | | |
|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 57,173.80 | 57,173.80 |
| **2105** | **Нормативт зардал** | 28,655.60 | 28,655.60 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 4,149.70 | 4,149.70 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 24,505.90 | 24,505.90 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 10,000.00 | 10,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,000.00 | 10,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 8,790.00 | 8,790.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 4,000.00 | 4,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 4,790.00 | 4,790.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 55.15 | 55.15 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 55,147.70 | 55,147.71 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 64.61 | 64.61 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 64,605.80 | 64,605.80 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 62,605.80 | 62,605.80 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 2,000.00 | 2,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,867,832.10 | 1,857,832.10 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,637,420.50 | 1,627,420.50 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,637,420.50 | 1,627,420.50 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 230,411.60 | 230,411.60 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 230,411.60 | 230,411.60 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ мян.төг /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **57,007.23** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **57,007.23** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **19,946.61** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **782.01** |
| 210401 | Бичиг хэрэг | 782.01 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **7,864.60** |
| 210604 | Урсгал засвар | 7,864.60 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **11,300.00** |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,300.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **37,060.61** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **37,060.61** |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 37,060.61 |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **61,903.75** |

| | | |
|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **61,903.75** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 16,978.53 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 37,060.61 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 7,864.60 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэл,тайлагнал, худалдан авалт, арвилан хэмнэлт зэрэгтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Завхан аймаг дахь Төрийн Аудитын аудитор Б.Жалбаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн Аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Улиастай сумын Жавхлант цогцолбор сургууль нь "Хэл соёлоо дээдлэн бүтээлч байцгаая, хүүхдийн хөгжлийг дэмжих, хичээл сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах" гэсэн зорилтын хүрээнд үйл ажиллагааг явуулж байна

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тус байгууллага нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг болон дотоод хяналтыг хэрэгжүүлэх журам, заавар зэргийг боловсруулж мөрдсөн байна.

Дотоод аудитын чиг үүрэг бүхий нэгж тус байгууллагад байхгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Улиастай сумын Жавхлант цогцолбор сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт орлого 2,356,000.1 мянган төгрөгийн 1 хувь буюу 23,560.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувь буюу 17,670.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг 2020 оны үзүүлэлтээр тооцсон тул гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг дахин шинэчлэх шаардлагатай гэж үзэн 2021 оны нийт орлого 2,038,605.9 мянган төгрөгийн 1 хувь буюу 20,386.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг ерөнхий материаллаг байдлын 75 хувь буюу 15,289.5 мянган төгрөгөөр тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 2,713.90 | 1,053.10 | -1,660.80 |
| Бараа материал | 233,683.60 | 310,941.40 | 77,257.80 |
| Үндсэн хөрөнгө | 1,393,380.60 | 1,324,415.40 | -68,965.20 |
| **Нийт хөрөнгө** | **1,629,778.10** | **1,636,409.90** | **6,631.80** |
| Өр төлбөр | 0.00 | 0.00 | 0.00 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,629,778.10 | 1,636,409.90 | 6,631.80 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,629,778.10** | **1,636,409.90** | **6,631.80** |

Авлага дансны үлдэгдэл 1,660.9 мянган төгрөг болж буурсан нь өмнөх оны авлагаас 1,660.8 мянган төгрөгийг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 310,941.4 мянга болж өссөн нь номыг бараа материалаар тусгасан, шинэ байр ашиглалтад орсонтой холбоотой анги танхимын тохижилтын материал худалдан авсан, малын нас дэвшилт, Азийн хөгжлийн банкнаас 18,454.2 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн олгосон зэрэгтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,324,415.4 мянган төгрөг болж буурсан нь элэгдлийн зардал болон 76,756.1 мянган төгрөгийн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,636,409.9 мянган төгрөг болж өссөн нь нь хуримтлагдсан үр дүн 5,244.8 мянган төгрөгөөр буурсан, дахин үнэлгээтэй хөрөнгө акталсан зэрэгтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Дээд шатны төсөв захирагч тус байгууллагын 2021 оны төсвийн зарлагыг 1,857,831.9 мянган төгрөгөөр, санхүүжүүлэх эх үүсвэрийг тусгай зориулалтын шилжүүлгээс 1,637,420.5 мянга, орон нутгийн төсвөөс 230,411.6 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр тусгай зориулалтын шилжүүлгээс 1,627,420.5 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 230,411.6 мянган төгрөгийн, нийт 1,857,832.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагааны зардалд 1,857,832.1 мянган төгрөгийг зарцуулжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд 61,903,7 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна. Үүнд:

- Дээд шатны төсөв захирагчаас хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллаж байгаа алба хаагчдын мөнгөн урамшуулалд 37,060.6 мянган төгрөг
- Урь оны үлдэгдлээс 4,314.6 мянган төгрөг
- Төсөвт байгууллагын үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлого 5,032.0 мянган төгрөг
- Номын түрээсийн үнэ 4,896.5 мянган төгрөг
- Олон улсын төсөл хөтөлбөрөөс 10,600.0 мянган төгрөг зэрэг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын үйл ажиллагаанд онцолж үзэх асуудал байхгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын үйл ажиллагааны зардал болох хүнсний материалыг нийлүүлэх бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулсан байдлыг санхүүгийн аудитаар шалгахад материаллаг алдаа зөрчилтэй асуудал илрээгүй.

**3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 131 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хугацаанд нь байршуулж, 18 мэдээллийг хугацаа хоцорч мэдээлсэн байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 87.9 хувьтай байна.

**3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд НББ-ийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлэн тайлагнаж Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй бөгөөд хүнсний материал дутагдсан 2,508.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоосон байна. Төлбөрийн актыг аудитын хугацаанд барагдуулсан байна.

**3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар авч үзэх материаллаг эрсдэлтэй асуудал ажиглагдаагүй болно.

**4. Аудитын илрүүлэлт**

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар нийт 10,285.2 мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна.

4.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар залруулах алдаа зөрчил илрээгүй болно.

4.2 Төлбөрийн акт

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар төлбөрийн акт тогтоох алдаа зөрчил илрээгүй болно

4.3 Албан шаардлага

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар албан хаагчдын дархлааг дэмжих зорилгоор хүүхдийн хоолноос будаа, элсэн чихэр, гоймон, аарц зэрэг 5,516.3 мянган төгрөгийн, уралдаан тэмцээн, ахмадын хүлээлт авалт, хүндэтгэлийн арга хэмжээнд аж ахуй, бичиг хэргийн зардлаас 4,768.9 мянган төгрөгийг зарцуулсан нь зориулалт бус байна. Иймд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

4.4 Зөвлөмж

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар зөвлөмж өгөх алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Жавхлант цогцолбор сургууль | 2 | 10.3 | | | | | 2 | 10.3 | | |

БОЛОВСРУУЛСАН:

АУДИТОР Б.ЖАЛБАА

ХЯНАСАН:

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.БАТ-УНДРАА

АХЛАХ АУДИТОР Б.ДАГВАСҮРЭН

2022.02.21

ATA6366 9039376
0921100007